



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Улсын мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 07-111/12 дугаартай актыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Автотээврийн төвд "Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх" 2017 оны 2017/007 дугаартай тусгай зөвшөөрлөөр олгогдсон техникийн хяналтын үзлэгийн явуулын төвийн үйл ажиллагааг 2018 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс сэргээсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т даалгасугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ